



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/261

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг
байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1/д заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагад ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн
дарга:

Захиргаа, удирдлагын газрын дарга

Нарийн бичгийн
дарга:

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Захиргаа,
хүний нөөцийн хэсгийн хөдөлмөр хамгааллын
мэргэжилтэн

Гишүүдэд:

Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн
дарга

Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн
дарга

Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

Аж ахуйн тасгийн дарга

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэлийн осол
хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын
комиссын нарийн бичгийн дарга

Нисэхийн сургалтын төвийн хөдөлмөрийн аюулгүй
ажиллагаа, галын аюулгүй байдлын хяналтын инженер

Иргэний нисэхийн ерөнхий газрын Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга

Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулинд заасан зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах, зөвлөлийн ажиллах журам болон ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, мөрдөхийг Зөвлөлийн даргад даалгасугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН